

Ээлжит хичээлийн хөтөлбөр-1

Сэдэв: Тэнхлэгийн тэгш хэм

Хугацаа: 40 минут

Зорилго: Өгөгдсөн шулууны хувьд цэгийг тэгш хэмтэй хувиргах хувиргалтын томъёог гаргах, дүрсийг тэнхлэгийн тэгш хэмээр хувиргах




Зорилт:

- Тухайн тохиолдлын жишээ бодолтоор ерөнхий тохиолдлыг гаргах, сурах бичгийн бодлогын бодох




Агуулга:

Өмнө судалсан агуулга	Цаашид судлах агуулга
- Төвийн тэгш хэмийн талаар судалж байгаагүй. Энэ нь шинэ ойлголт юм.	- Төвийн тэгш хэмийн дараалсан хувиргалт хийх

Цагийн төлөвлөлт:

Хичээлийн бүтцийн явц	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
Хичээл зохион байгуулалт - 1 минут	- Сурагчидтай мэндлэнэ - Хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэнэ.	- Багштай мэндлэнэ - Сурагчид хичээлийн бэлтгэл байдлыг хангана.
Сэргээн санах (Сэдэлжүүлэлт) - 5 минут	Өнөөдрийн бодлого: 1. ABC гурвалжныг O_y тэнхлэгийн хувьд тэгш хэмтэйгээр хувиргажээ. Оройн цэгийн координатуудыг олно уу. Координатуудаас юуг ажиглаж байна вэ? 2. ABC гурвалжныг O_x тэнхлэгийн хувьд тэгш хэмтэйгээр хувиргажээ. Оройн цэгийн координатуудыг олно уу. Координатуудаас юуг ажиглаж байна вэ?	
Шинэ хичээл - 15 минут	Тодорхойлолт: Хавтгайд a шулуун өгсөн байг. Уг хавтгайн аливаа цэгийг a шулууны хувьд тэгш хэмтэй цэгт шилжүүлэх хувиргалтыг тэнхлэгийн тэгш хэм гэнэ. a шулууныг тэгш хэмийн тэнхлэг гэнэ. Тэгш хэмийн тэнхлэгийн аливаа цэг нь үл хөдлөх цэг байна. Өнөөдрийн бодлого: $x - 3.5 = 0$ шулууны хувьд тэгш хэмийн хувиргалтын томъёог гарга. Энд $P(x, y)$, $P'(x', y')$ байна. 1. Тэгвэл PP' хэрчмийн хувьд M ямар шинж чанартай цэг вэ? 2. P' цэгийн координатыг M, P цэгийн координатын тусламжтайгаар хэрхэн олох вэ? 3. Гаргасан томъёогоо бичнэ үү?	 <p>$P(x, y)$ цэгийн дүр $P'(x', y')$ байг. PP' хэрчим тэгш хэмийн тэнхлэгтэй огтлолцох цэгийг M гэе. Тэгвэл M цэг тэгш хэмийн тэнхлэг дээр орших тул 3.5 байна. PP' хэрчим O_x тэнхлэгтэй параллель тул $y' = y$ байна. Иймд $M(3.5, y)$ байна. M цэг PP' хэрчмийн дундаж тул $3.5 = \frac{x+x'}{2}$ $y = \frac{y+y'}{2}$ болно.</p>
Бататгах - 10 минут	1. Өгсөн дүрсийг өгсөн шулууны хувьд тэгш хэмээр хувиргаж зур.	

2. Дүрс болон түүний тэнхлэгийн тэгш хэмээр хувиргахад гарах дүрийг өгөв. Тэгш хэмийн тэнхлэгийн зур, тэгшитгэлийг нь зохио.



Дүгнэлт
2 мин

Хувиргалтын томъёог гаргаж, дэвтэртээ хүснэгтийг нөхөж бич.

Тэгш хэм	O_x тэнхлэгийн хувь дахь	O_y тэнхлэгийн хувь дахь	$y = x$ хувь дахь	$y = -x$ хувь дахь
Хувиргалтын томъёо				

Гэрийн
даалгавар
- 2 минут

Сурах бичгээс бодлого өгнө.